



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн спортын VI наадмын хаалтын ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн спортын VI наадмын хаалтын ажиллагааг 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 5.190.000 /таван сая нэг зуун ерэн мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн Биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга /А.Болдмаа /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 56 дугаар тушаалын хавсралт



Нийслэлийн иргэдийн спортын VI наадмын хаалтын ажиллагааг зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багийн шагнал: 1 x 500.000 төг = 500.000 төг 1 x 450.000 төг = 450.000 төг 1 x 400.000 төг = 400.000 төг	1.350.000
2.	Шилдэг хороодын шагнал	800.000
3.	Заал талбайн зардал	2.000.000
4.	Өргөмжлөл	440.000
5.	Анонс, цом	600.000
ДҮН:		5.190.000

Боловсруулсан
Хянасан

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг